



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2015 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 07/90

Жавхлант

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт, лабораторийн шинжилгээ хийх
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, лабораторийн оношлох, тандах, шинжилгээ хийх төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулж гүйцэтгэхийг "Түмэн сувд" ХХК-ны захирал (Ч.Амартүвшин), малын эмч (М.Орхонтуул), "Дэлгэрэх наран эрдэнэ" ХХК-ны захирал (Д.Жавзмаа), "Эх цаг" ХХК-ны захирал (Ч.Нацаг), "Бидний оролцоо зөв" ХХК-ны захирал (Д.Баяртуяа) нарт үүрэг болгосугай.

2. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчин, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай вакцин, био бэлдмэл, эмийн бодис, урвалж, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянан шалгаж, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Шижирбаатар)-т үүрэг болгосугай.

3. Товолсон хугацаанд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулахыг малчин, мал бүхий иргэдэд мэдэгдэж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Г.Энхзаяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН